



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/534

Есөнбулаг

Орон нутгийн хамгаалалтын томилгоот
нэгжийн удирдах бүрэлдэхүүнтэй
дадлага, сургалт явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.6, 11.7 дахь хэсэг, 11.3.2, 11.4.2 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Батлан хамгаалахын сайдын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн "Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн сургалтад дэмжлэг үзүүлэх тухай" А/110 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 4.3.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын батлан хамгаалах зарим чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэхээр Батлан хамгаалахын сайд, аймгийн Засаг даргатай 2024 онд хамтран ажиллахаар байгуулсан гэрээний 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний хээрийн дадлага сургалтыг Төгрөг сумын нутагт 2024 оны 09 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд сахилга хариуцлагын өндөр түвшинд зохион байгуулж ажиллахыг Цэргийн штаб (хурандаа Д.Төмөрбаатар)-д үүрэг болгосугай.

2.Орон нутгийн хамгаалалтын хээрийн дадлага сургалтыг зохион байгуулахад шаардагдах 7.000.000 (долоон сая) төгрөгийг хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

3.Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний хээрийн дадлага, сургуульд шаардагдах бараа материал, шаардлагатай хэрэгслээр дэмжлэг үзүүлж ажиллахыг Зэвсэгт хүчний 341 дүгээр ангийн захирагч (хурандаа Б.Энхбаяр), Хилийн цэргийн 0214 дүгээр ангийн захирагч (хурандаа Э.Майдар), Онцгой байдлын газар (дэд хурандаа Ц.Лувсанжамц), Цагдаагийн

газар (цагдаагийн хурандаа Н.Мэндбаяр), Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар (хошууч Г.Ганбат) нарт болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд тус тус даалгасугай.

4.Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн удирдах бүрэлдэхүүний хээрийн дадлага, сургуулийн бэлтгэл ажлыг сайтар ханган, томилгоот бүрэлдэхүүнийг бүрэн хамруулж ажиллахыг Алтай, Бугат, Дарив, Цээл, Төгрөг, Тонхил, Халиун, Шарга сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

2024 оны 09 дүгээр сарын 09-ны
 өдрийн 4 дугаар захирамжийн
 хавсралт

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТОМИЛГООТ НЭГЖИЙН
 БҮРЭЛДЭХҮҮНТЭЙ ЯВУУЛАХ ХЭЭРИЙН ДАДЛАГА, СУРГАЛТАД
 ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зардлын төрөл	Тоо, ширхэг	Нэг бүрийн үнэ	Бүгд	Тайлбар
1	Хоолны зардал мах гурил, будаа, гоймон, ногоо /80 хүнийг 3 өдөр хооллох/	Хонины 4, ямааны 4 мах Гурал 2 уут Будаа 50 кг Гоймон 30 кг Ногоо төмс 35 кг Байцаа 25 кг Лууван 10 кг Сонгин 5 кг	380000 210000 25кг=58000*4 50кг*4000 30кг*6500 35кг*2200 25кг*3850 10кг*3850 5кг*3850	1.520.000 840.000 232.000 200.000 195.000 77.000 96.250 38.500 19.250	
2	Аймгийн зураг хэвлүүлэх (200*150)	2ш Зураг-1мкв	65000	390.000	
3	Цэргийн штабын офицеруудын хөдөлгөөнт бүлгийн автотехникийн шатахууны зардал	0809 ГАА	470 км 94л / ирж очих 320 км, дотор үйлчилгээ 150 км/	94л*2800= 263.200	
		ЦАБ	470 км 94л / ирж очих 320 км, дотор үйлчилгээ 150 км/	94л*3850= 361.900	Сум, галт хэрэгсэл бусад ачаа
		Алтай	300 км 45л	45л*3850= 173.250	
		Бугат	120 км 21,6л	21,6л*3850= 83.160	
		Дарив	200 км 30л	30л*3850= 115.500	
		Тонхил	200 км 30л	30л*3850= 115.500	
		Халиун	280 км 42л	42л*3850= 161.700	
		Цээл	420 км 63л	63л*3850= 242.550	
4	Сургалтын хэрэглэгдэхүүнүүд	бичгийн цаас 3 боодол	20000х6	120.000	
		Фото цаас 3 боодол	18000х3	54.000	
		Өнгөт принтерийн хор 1 удаа	72000	72.000	
		Буудлагийн бай 10 ш аравчын хамт	54165	54165	
5	Сургалтын контент бичлэг хийх	2	500.000	1.000.000	
	бусад		500.000	500.000	
Нийт 7.000.000					